

СУМЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГЛӨӨ

Нэг. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, иргэдийнхээ санаа бодлыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас гарах шийдвэрүүдэд тусган хэрэгжүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх ажлуудад томоохон ахиц гаргахын төлөө хичээн ажиллах болно.

Хоёр. Орхон сум суурийг анх 1968 онд тавьснаас хойш эдүгээ 3200 хүн амтай, олон улсын авто болон төмөр замын зангилаан дээр байрладаг, төвийн эрчим хүчний системд холбогдсон юм.

Гурав. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, иргэдийнхээ санаа бодлыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргаас гарах шийдвэрүүдэд тусган хэрэгжүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх ажлуудад томоохон ахиц гаргахын төлөө хичээн ажиллах болно.

Алсын хараа: Мэдлэг чадварт суурилсан мэргэшсэн захиргааны байгууллага болох

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛГО

Сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь сумынхөгжлийн цогц бодлого, аймгийн болон Тамгын газрын стратеги, тэргүүлэх чиглэл, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын болон аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, зорилт, аймгийн Засаг даргын даргын эрхлэх ажлын хүрээний бодлогыг төлөвлөх, боловсруулах, удирдлага, зохицуулалтын болон дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөлгөө, бүх талын дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Сумын Засаг даргын Тамгын газар нь үйл ажиллагааны дор дурдсан тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

2.1. Сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого (стратегийн төлөвлөлт)-ыг тодорхойлох, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлээр аймгийн Засаг даргад зөвлөлгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх;

2.2. Сумын Засаг даргын болон сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, тэргүүлэх чиглэл, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх, бодлого, шийдвэрийг боловсруулан гаргахад сумын Засаг дарга, эрхлэх асуудлын хүрээний төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд бүх талын зөвлөлгөө, дэмжлэг үзүүлэх, Сумын Засаг даргын зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

2.3. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний шинэчлэлийн бодлого, орон нутгийн хөгжлийн нэгдсэн бодлого, төрийн албаны хүний нөөцийг давтан сургах асуудал, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын шийдвэрийн биелэлт, дотоод мэдээлэл, аймгийн Засаг даргаас Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай харилцах асуудалд арга зүйн зөвлөлгөө, бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

2.4. Аймгийн Засаг даргын болон сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, тэргүүлэх чиглэлийг хэрэгжүүлэхэд агентлаг, сумдын ЗДТГ-ын үйл ажиллагааг чиглүүлэх, бодлогын удирдамжаар хангах, зохицуулах, бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, мэдээлэх;

2.5. Сумын төрийн байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, мэдээллийн урсгалыг түргэтгэх, Тамгын газар-хувийн хэвшил, Тамгын газар-иргэний нийгмийн түншлэлийг хөгжүүлэх;

Дэлгэрэнгүй мэдээлэл авах:
Засаг даргын Тамгын газрын
дарга : С.Дэлгэржаргал
203 тоот Утас: 7037-2626